



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 48

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх санал уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3-ын “д” заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. ХТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, тус бүрийн анхны өртөг нь 49,500.495 төгрөг, элдэгдэл нь 9,075.090.75 төгрөг, үлдэх өртөг нь 40,425.404.25 төгрөгийн 2 экоавтобусыг Хүмүүнлэг сургууль болон Мандал сургуулийн дансанд, сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй анхны өртөг нь 218,840.729,11 төгрөг, элдэгдэл нь 18,236.727.36 төгрөг, үлдэх өртөг нь 194,525,092.63 төгрөгийн МСҮТ-ийн сурагчдын хуучин дотуур байрыг Цэгцбилиг сургуулийн дансанд тус тус балансаас балансад шилжүүлэх тухай саналыг дэмжиж дээд шатны байгууллагад уламжилсугай.

2. Тус үндсэн хөрөнгийн холбогдох бичиг баримтын бүрдлийг хангаж аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдэд хүргүүлэхийг ХТГ-ын дарга (Д.Очбадрах), ЗДТГ-ын дарга (Ц.Лхагвасүрэн) нарт даалгасугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ